## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД БАЙГУУЛЛАГА, САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА ШИЙДВЭРҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2026 оны 03 дугаар сарын 20 -ны өдөр

Байгууллагын нэр: Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба

| д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр, огноо, дугаар | 2025 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт | Хэрэгжээгүй эсвэл хэрэгжилт хангалтгүй аль нь болох | | Хэрэгжилт (хувь) | Шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгжээгүй | Хэрэгжилт хангалтгүй | | |
| Монгол Улсын хууль | | | | | | |
| 1 | Чөлөөт бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-02-12<br>Дугаар 2015.02.12 | Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2022 оны А/10 дугаартай тушаалаар Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар сайдын багцаас 214.9 сая төгрөг төсөвлөгдөн сонгон шалгаруулалт зарлаж Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ийн түншлэл шалгарч 2022 онд 304 дугаартай гэрээг байгуулсан. Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ний түншлэл байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүй тул 2025 онд 304 дугаартай гэрээг цуцалсан. Монгол Улсын Шадар Сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 50 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан 300.0 сая төгрөгөөр Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах аж ахуй нэгжийн тендер шалгаруулалт Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр худалдан авах ажиллагаа зарлагдаж нэг аж ахуй нэгж ерөнхий төлөвлөгөө боловсруулах санал ирүүлсэн ч шаардлага хангаагүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болж төсөв татагдсан.<br>Монгол Улсын Шадар сайд Алтанбулаг чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгсөн. Үүнтэй холбоотойгоор Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ний түншлэлийн гүйцэтгэж буй ерөнхий төлөвлөгөөг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Засгийн газраар батлуулах, мэргэжлийн зөвлөл болон экспертизээр хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | | | 90% | Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах аж ахуй нэгжийн тендер шалгаруулалт Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр худалдан авах ажиллагаа зарлагдаж нэг аж ахуй нэгж ерөнхий төлөвлөгөө боловсруулах санал ирүүлсэн ч шаардлага хангаагүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болж төсөв татагдсан. |
| | | Монгол Улсын Шадар Сайдын ажлын албанд “Чөлөөт бүсэд мөрдөх журам” болон Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”, Чөлөөт бүсэд тамхи худалдах энгийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”-д өөрчлөлт оруулах саналыг боловсруулан хүргүүлсэн. | | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| УИХ-ын тогтоол | | | | | | |
| 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023-05-04 Дугаар 2023_32 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны ёс зүйн дэд хорооны 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг баталж, мөрдлөг болон ажиллаж байна. | | | 100% | |
| 3 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2023-06-30 Дугаар 2023_59 | Байгууллагын хэмжээнд "Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөний дагуу холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллалаа.<br>1. "Алтанбулаг чөлөөт бүс"-д үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээ олгох үйлчилгээг "И-Монгол Академи" УТҮГ-тэй хамтран 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн www.e-business.mn цахим хэлбэрээр хүлээн авч нийт 42 хуулийн этгээдийн хүсэлтийг шийдвэрлээд байна.<br>2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд нээлттэй байхаар заасан байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний мэдээлэл тус бүрийг байгууллагын цахим хуудас болон www.shilen.gov.mn хуудсаар ил тод нээлттэй байршуулж хуулийн хэрэгжилтийг ханган улирал тутам тайланг илгээн дүгнүүлсэн.<br>“Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлэх” зорилгын зорилт болох төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн тогтвортой байдлыг хангах үүднээс байгууллагын сул орон тоог Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нөөцөд байгаа иргэд болон байгууллагаасаа албан тушаалын шаардлага хангасан албан хаагчдаас АТГ-т хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсны үндсэн дээр шаардлага хангасан иргэдийг тухайн албан тушаал томилон ажиллууллаа. | | | 100% | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 4 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган тус төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | | | 100% | |
| | | Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дэргэдэх ёс зүйн хороог 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Захирагчийн А/07 дугаартай захирамжаар 5 гишүүнтэй байгуулагдсан. Алтанбулаг чөлөөт бүс байгууллагын дэргэдэх ёс зүйн хороо байгуулагдаж ХНУМТ-д системд бүртгүүлэн тус | | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | системийн дагуу 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж байгууллагын албан хаагчдад төрийн бус байгууллагатай хамтран гурав удаа ёс зүйн сургалт зохион байгуулж, улирал тутам ажлын тайланг тайлагнасан. | | | | |
| | | Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн 2025 оны 06 дугаар сарын 20 – ны өдрийн Б/33 дугаартай захирамжаар ёс зүйн дэд хорооны 5 гишүүнд урамшуулал олгон ажиллаж байна. | | | 100% | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 5 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд Чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн хамтаар Алтанбулаг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт мод тарьсан бөгөөд цаашид “Алтанбулаг” чөлөөт бүсийн 500 га талбайн 50 га буюу 30 хувьд нь мод тарих бэлтгэл ажлыг хангаж Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн “Енисей” ХХК-иас үрсэлгээ, модны үр авахаар болсон. | | | 100% | |
| 6 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигын дагуу Эзэн богд Чингис хааны эш хөргийг захирагчийн ажлын албан дээрээ хүндэтгэн залсан. | | | 100% | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | |
| 7 | Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139 | 1. 2025 онд Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч;<br>2. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч;<br>3. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч;<br>4. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчид тус тус хамрагдсан. | | | 100% | |
| 8 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем /hrm.csc.gov.mn/-д албан хаагчдийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлтийг тогтмол оруулан мэдээллийг шинэчлэн ажилласан | | | 100% | |
| 9 | Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь “И Монгол академи” УТҮГ-тай хамтран 2025 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн чөлөөт бүсэд согтууруулах ундаа болон тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээг e-business.mn-ээр дамжуулан иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж байна. | | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024-12-20<br>Дугаар 2024_226 | Төрийн захиргааны байгууллагуудыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баярын өдөр, цагаан сарын баярын өдрүүдэд болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр, цагаан сарын өдрүүдээр хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган Улаанбаатар хот, Алтанбулаг чөлөөт бүсийн нутагт дэвсгэрт ажиллуулсан | | | 100% | |
| 11 | Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04<br>Дугаар 2025_279 | 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амраасанг 2025 оны 08 дугаар сарын 16, 23-ны бямба гарагуудад нөхөн ажилуулсан. | | | 100% | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 12 | 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл<br>2023-04-05<br>Дугаар 2023_15 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг чөлөөт бүсэд хийгдэж байгаа 35кВа-ийнцахилгаан хангамжийн өргөтгөл ажлыг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS) программ дээр хийж байна. | | | 100% | |
| 13 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл<br>2025-01-14<br>Дугаар 2025_03 | Төвийн бүсийн хөгжлийн чуулган одоогийн байдлаар зохион байгуулагдаагүй байна. | Хэрэгжээгүй | | 0% | Монгол Улсын Засгийн газраас төвийн бүсийн хөгжлийн чуулганг зарлан хуралдуулаагүй. |
| 14 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-01-29<br>Дугаар 2025_06 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн хилийн чанад руу чиглэсэн гадаад гарц/орц/ нээх асуудлыг судлан танилцуулах ШСАА-аар ахлуулсан яам, мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулан үе шаттайгаар ажиллаж байна. | | | 100% | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | |
| 15 | 2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12<br>Дугаар 2024_01 | ОБЕГ, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсээс зохин байгуулсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" уулзалтанд оролцож заавар зөвөлгөө авч улмаар 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Засгийн Газрын 11 дүгээр байранд нүүлгэн шилжүүлэх тактикийн сургууль, ЧД-ийн гал унтраах 10 дугаар ангид гал унтраах, газар хөдлөлтөөс сэргийлэх сэргийлэх сургалтанд албан хаагчид оролцсон. Онцгой байдлын ерөнхий газрын www.nema.gov.mn сайтын “Хяналтын хуудас” цэсэнд байршуулсан “Аюулгүй өрх” хяналтын хуудас, иргэний гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг шалгах асуумжийг албан хаагчид бөглөн зөвлөмжтэй танилцаж гамшгаас хамгаалах анхан шатны мэдлэгтэй болсон. | | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2025-03-06 Дугаар 2025_02 | Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2022 оны А/10 дугаартай тушаалаар Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар сайдын багцаас 214.9 сая төгрөг төсөвлөгдөн сонгон шалгаруулалт зарлаж Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ийн түншлэл шалгарч 2022 онд 304 дугаартай гэрээг байгуулсан. Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ний түншлэл байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүй тул 2025 онд 304 дугаартай гэрээг цуцалсан. Монгол Улсын шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 50 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан 300.0сая төгрөгөөр Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах аж ахуй нэгжийн тендер шалгаруулалт Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр худалдан авах ажиллагаа зарлагдаж нэг аж ахуй нэгж ерөнхий төлөвлөгөө боловсруулах санал ирүүлсэн ч шаардлага хангаагүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болж төсөв татагдсан.<br>Монгол Улсын шадар сайд Алтанбулаг чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгсөн. Үүнтэй холбоотойгоор Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ний түншлэлийн гүйцэтгэж буй ерөнхий төлөвлөгөөг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Засгийн газраар батлуулах, мэргэжлийн зөвлөл болон экспертизээр хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | | | 90% | Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах аж ахуй нэгжийн тендер шалгаруулалт Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр худалдан авах ажиллагаа зарлагдаж нэг аж ахуй нэгж ерөнхий төлөвлөгөө боловсруулах санал ирүүлсэн ч шаардлага хангаагүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болж төсөв татагдсан. |
| 17 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01 | Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дэргэдэх ёс зүйн хороог 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Захирагчийн А/07 дугаартай захирамжаар 5 гишүүнтэй байгуулагдсан. Алтанбулаг чөлөөт бүс байгууллагын дэргэдэх ёс зүйн хороо байгуулагдаж ХНУМТ-д системд бүртгүүлэн тус системийн дагуу 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж байгууллагын албан хаагчдад хоёр удаа ёс зүйн сургалт хийж, төрийн бус байгууллагатай хамтарч сургалт зохион байгуулж, улирал тутам ажлын тайланг тайлагнан ажиллаж байна. | | | 100% | |
| 18 | Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-07-25 | Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дэргэдэх ёс зүйн хороог 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Захирагчийн А/07 дугаартай захирамжаар 5 гишүүнтэй байгуулагдан ажиллаж байна. | | | 100% | |
| | | Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл / Сэлэнгэ, Алтанбулаг сум/ -ийн барилга угсралтын ажил:<br>• 35/10кВ-ын 2*4000кВА чадал бүхий дэд станцын тэжээл болох 4км 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-ын угсралтын ажил 100 хувь. | | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | • 35/10кВ-ын 2*4000кВА чадал бүхий дэд станцын угсралтын ажил 100 хувь.<br>• 35кВ-ын Сүхбаатар 110/35/6кВ-ын дэд станцаас Алтанбулаг сум хоорондох 21,4 км 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-ын утас солих угсралтын ажил 100 хувь.<br>• Хувиарлах байгууламж 2 ком 100 хувь<br>• 2*630кВА чадал бүхий 8 ком ХТП маягийн дэд станц 100 хувь<br>• 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам 100 хувь<br>• 110/35/6кВ-ын Сүхбаатар дэд станцын өргөтгөлийн хүрээнд 2*25МВА хүчний трансформатор, 6,35,110кВ талын тоноглолуудыг тус бүр суурилуулан хүчдэлд залгасан бөгөөд хэвийн ажиллаж байна. | | | | |
| 19 | Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2025-07-25<br>Дугаар 2025_04 | Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбогдуулан чөлөөт бүсийн тухай хууль, салбарын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын төсөлтэй уялдуулан холбогдох дүрэм, журмуудыг нягтлан судалсан.<br>Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 96 дугаар тушаалаар Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж<br>Чөлөөт бүсийн тухай хуульд үнэлгээ хийх, хуулийн зүйл заалт хэрэгжиж байгаа болон хэрэгжихгүй байгаа шалтгааныг тодорхойлох, цаашид өөрчлөх шаардлагатай хуулийн зүйл хэсгийг тодорхойлж, өөрчлөлт оруулах агуулгыг санал болгох, үзэл баримтлал боловсруулах ажил хийгдэж байна. | | | 100% | |

-о0о-